



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 24/05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Бодь Даатгал” ХК-ийн Дүрмийн 7.1, 7.3 дугаар зүйлийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 05-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 11:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн /Agm.mn/ веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03 сарын 06-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2024 оны 03 сарын 07-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2024 оны 03 сарын 22-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Ногдол ашиг авах болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 03 сарын 11-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал А.Энхжаргал,
Гишүүд: Үйл ажиллагааны газрын захирал М.Мөнхбаатар, ТУЗ-н Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг, Бизнес хөгжлийн газрын захирал Д.Пүрэвтулга, Эрсдэл хариуцсан дэд захирал Б.Алтанзул, Хангамж, худалдан авалт хариуцсан ахлах менежер Г.Нарантуяа,
7. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
8. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
9. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

10. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
11. Хурлын материалыг 2024 оны 03 сарын 11-ний өдөр брокер, диллерын компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд “БОДЬ ДААТГАЛ” ХК-ийн төв байр, хаяг: Ц.Жигжиджавын гудамж-3, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, ирж танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж харъяалагдах үнэт цаасны компаниудаар дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 15:00 цаг байна.
13. Хурлын даргаар Бодь Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхжаргалыг томилсугай.
14. Хурлын тооллогийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд: Тооллогын комиссын дарга: Ахлан хуульч Х.Сарангоо, Гишүүд: Хуульч Б.Анар-эрдэнэ, ICD албаны мэргэжилтэн С.Пүрэвжаргал, С.Хулан нарыг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
15. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга А.Энхжаргалд даалгасугай.
16. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ